



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/158.

Мандалговь

Газар эзэмших эрхийг хэсэгчлэн шилжүүлэх тухай

Монгол улсын газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх заалтууд, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Худалдааны гудамж-2-212)-т байршилтай иргэн Чулуун овогтой Лхагвасүрэн (ЗЮ:56022113)-ийн хамтран эзэмшигч Лхагвасүрэн овогтой Мөнхзул (ЗЮ:79071402) үйлчилгээний зориулалттай 633 м.кв (0,06га) газрын 56 м.кв (0,0056га) газрыг иргэн Пүрэвжав овогтой Энхтамир (ХД:86060617)-д худалдааны гудамж-2-212а тоот хаягт зориулалтаар нь шилжүүлж, үлдсэн 576 м.кв (0,05га) иргэн Чулуун овогтой Лхагвасүрэн (ЗЮ:56022113)-д, хамтран эзэмшигчээр Лхагвасүрэн овогтой Мөнхзул (ЗЮ:79071402) -д (Худалдааны гудамж-2-212) тоот хаягт зориулалтаар 22 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэдтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2013 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/566 дугаар захирамжийн иргэн Ч.Лхагвасүрэн-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000051248(Худалдааны гудамж-2-212тоот) тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



481210438